



ҮАГазрын харъяа Баян-Өлгий аймгийн Аудитын газар

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аймгийн Засаг даргын тамгын газрын
2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон
жилийн эцсийн санхүүгийн тайлан

Аудитын код: БӨА-2017/83/СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас: www.bayan-ulgii.tvet.gov.mn

Тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 99417382 Цахим хаяг: mhkuangan@yahoo.com

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930, 99932710 Цахим хаяг: kh_jenisbek@yahoo.com

Аудитор: Б.Үүрийнтуяа

Утас: 89838414 Цахим хаяг: Elbegeeuuree@yahoo.com

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	6
2.1	Оршил	6
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	6
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	7
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	7
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	8
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	9
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	10
2.9.1	Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал	10
2.9.2	Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал	10
2.9.3	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	10
2.9.4	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	11
2.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	11
2.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	11
2.12	Шилэн дансны мэдээлэл	12
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	12
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	12
3	Менежментийн захидал	14
3.1	«management_zurchil1»	Error! Bookmark not defined.
3.2	«management_zurchil2»	Error! Bookmark not defined.
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	16
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	16
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	17
4.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..	Error! Bookmark not defined.
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	19
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	22

1 Аудитын гэрчилгээ

Баталгаажуулсан гэрчилгээг сканнердаж оруулах



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Х.ТИЛЕГЕН ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 70422954, 70422930
E-mail: bayanulgi@audit.gov.mn

2017.02.24 № 27 БА-2017/02-ТМ
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Аймгийн Засаг даргын тамгын газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон, жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1-д заасан бүрэн эрхийн дагуу Үндэсний аудитын газрын харьяа Баян-Өлгий аймгийн аудитын газраас аудит хийв.

Төсвийн захирагч нь тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Аймгийн Засаг даргын тамгын газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Sanal Sh.doc

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулга материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн.

Зөрчилгүй санал дүгнэлт

Аймгийн Засаг даргын тамгын газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.ХУАНГАН

Sanal Sh.doc

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга Х.Тилеген танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Аймгийн Засаг даргын тамгын газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аймгийн Засаг даргын тамгын газрын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017.02.20-наас 2017.02.24-ны хооронд хийж, аудитын тайланг 2017.02.24-нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Аудитын газрын аудитор Б.Үүрийнтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Аймгийн Засаг даргын тамгын газар нь 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2017.01.25 - нд төрийн аудитын байгууллагад 2017.01.24-ны өдрийн 3-02/153–р албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Аймгийн Засаг даргын тамгын газар *"Төр засгийн бодлого, шийдвэр тэдгээрийн хэрэгжилтийн үр дүнд хяналт шинжилгээ, хяналт шалгалт хийж үнэлгээ өгөх, нэгтгэж тайлагнахад хяналт тавьж, удирдлагыг үр ашигтай мэдээллээр хангах, зөвлөмж дэмжлэг үзүүлэх, дүгнэлт гаргах, үр дүнг сайжруулах"* гэсэн эрхэм зорилгын дор Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд дараах үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

Аймгийн Засаг даргын тамгын газар дээрх хуулиар тогтоосон чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд өөрийн эрхлэх асуудал, үйл ажиллагааныхаа чиглэл, цар хүрээг дараах байдлаар тодорхойлж баталгаажуулжээ. Үүнд:

Тайлант хугацаанд Аймгийн Засаг даргын тамгын газар нь *"Төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх, албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, хүний нөөцийн хөгжлийг хангах, хариуцлага, хяналтын тогтолцоог төгөлдөржүүлэх, гадаад харилцааг өргөжүүлэх"* дэвшүүлэн ажиллажээ.

Аймгийн Засаг даргын тамгын газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Аймгийн Засаг даргын тамгын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн

байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд эрх зүйн орчинтой холбоотой өөрчлөлт, шинэчлэлт хийгдээгүй байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Засаг даргын тамгын газрын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед “бага” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Аймгийн Засаг даргын тамгын газрын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 2 буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Тус газарт 2016 онд Засаг даргын дэргэдэх дотоодын аудитын албанаас 2014-2016 онуудын санхүүгийн баримтанд шалгалт хийгдсэн байна. Үйл ажиллагаатай холбоотой зөрчил дутагдал илрээгүй, Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтын талаар зөвлөмж өгөгдсөн байна.

Аймгийн Засаг даргын тамгын газар нь санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “Аколоус” програм хангамж ашиглажээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аймгийн Засаг даргын тамгын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 24 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 13 асуудал эрсдэл өндөр, 5 асуудал эрсдэл дунд, 0 асуудал эрсдэл бага гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 54 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 13 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих – шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт хөрөнгийг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт хөрөнгийг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төлөвлөлтийн шатанд нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгож төлөвлөсөнтэй холбоотой юм.

Аймгийн Засаг даргын тамгын газрын 2016 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1601,3 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь 32,0 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь эрсдлийн үнэлгээний түвшинтэй холбоотой юм.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 8 чиглэлээр 22 эрсдэлтэй асуудалд 22 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 10 хувь буюу 2 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(Сая төгрөгөөр)				
№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	1	0.0	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	8.3	
3	Албан шаардлага өгсөн	0	0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
Дүн		2	8.3	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Зөвлөмж болгохоор шийдвэрлэсэн буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3 дугаар бүлгийн Менежементийн захидалд холбогдох зөвлөмжийн хамт оруулав.

Харин бусад материаллаг буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн байдлаар дараах заалтад ангилан харуулав.

2.9.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал

ЗДТГазрын 2016 оны санхүүгийн тайлангийн завсрын болон гүйцэтгэлийн баталгаажуулалтын аудитаар ажиллагсадын цалин тогтоолт /албан тушаалын цалингийн шатлал, нэмэгдэлүүд/-нд түүвэр сорил хийж шалгаж үзэхэд СТСХэлтсийн мэргэжилтэн Т.Назым 2011 онд анх ажилд орохдоо цалинг тогтоохдоо төрд ажилласныг нотлох баримтгүй байхад төрд ажилласан хугацааг 12 жилээр үндэслэлгүй илүү тогтоон, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг илүү олгож, цалингийн шатлалыг ахиу сонгуулсан зэргээр 2011-2016 онуудад нийтдээ 8297028 төгрөгийн цалинг илүү олгосон нь Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын 2010 оны 239, 2012 оны 78, 2014 оны 332 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээ”-г зөрчиж байгаа учраас акт тогтоов.

Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал

Үгүй

2.9.2 Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Үгүй

2.9.3 Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Үгүй

2.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Тус газрын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар цаг хугацааны шахуу байдлаас шалтгаалж бүрэн үзэх боломжгүй түүврийн аргаар үзсэн тул Засаг даргын нөөц хөрөнгө, давсан хэсгийн зарцуулалтыг дараагийн аудитаар үзэх шаарлагатай гэж үзэв.

Тайлант онд анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй.

2.11 Төсвийн гүйцэтгэлийн ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Аймгийн Засаг даргын тамгын газар өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 1609,5 мянган төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Аймгийн Засаг даргын тамгын газрын төсвийн захирагч нь 2016 онд 1609,6 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр урсгал зардалд 1584,2 сая төгрөгийн зарлага санхүүжилт хийгдэж, 25,4 сая төгрөгийг оны эцэст төсөвт төвлөрүүлсэн байна.

/Сая төгрөгөөр/					
№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1609,6	1584,2	1.6%	25,4
1.1	Урсгал зардал	1609,6	1584,2	1.6%	-25,4
1.2	Хөрөнгийн зардал	0	0	0.0%	0.0
1.3	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	0	0	0.0%	0.0
2	Зардлыг сахуужүүлэх эх үүсвэр	1609,6	1584,2	1,6%	25,4

2.1	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1609,6	1584,2	1,6%	25,4
2.2	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих				
2.3	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос				

Урсгал зардлуудаас гэрэл цахилгаан, бичиг хэрэг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний зардлуудыг 0,3-2,2 сая төгрөгөөр хэтрүүлж, тээвэр шатахуун, шуудан холбоо, томилолт, бага үнэтэй түргэн элэгдэх зардлуудын хэмнэлтээс гүйлгэн зарцуулжээ.

Нийт төсвийн 41,3 хувийг цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 58,6 хувийг бараа үйлчилгээний бусад зардлууд эзэлж байна. Тус газарт тайлант онд өөрийн орлогын төлөвлөгөө өгөгдөөгүй байна.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар нийт 559,0 сая төгрөг зарцуулснаас 140,1 сая төгрөгийн цалин, нийгмийн даатгалын шимтгэл, сая төгрөгийг бусад урсгал зардалд зарцуулж, үерт автсан айл өрхөд Казакстан улсаас 418,9 сая төгрөгийн буцалтгүй тусламжийг олгосон байна.

Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг түүврийн аргаар орлогыг түүвэрлэж баталгаажуулав.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Аймгийн Засаг даргын тамгын газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно. Шилэн дансны хуультай холбоотой байж болох эрсдэлийн хүчин зүйлсийг судлах явцад 22 эрсдэлтэй асуудал тогтоогдож, 22 горим сорил хэрэгжүүлэв.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Засаг даргын тамгын газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Аймгийн Засаг даргын тамгын газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль,

УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.8-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв..

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Аймгийн Засаг даргын тамгын газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.

3.1

Илрүүлэлт

Ажилтнуудын төрийн алба хаасан хугацаа, цалингийн шатлал, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шалгаж үзэхэд цалингийн шатлалыг төрийн алба хаасан хугацаагаар биш нийт ажилласан жилээр шатлалыг сонгож, төрд ажилласан хугацааны нэмэгдлийг зарим ажилтанд илүү, зарим ажилтанд дутуу олгож, зарим ажилтны төрд ажилласныг нотлох баримтгүй байхад төрийн албан хаагчийн анкетэнд бичснийг үндэслэн төрийн албад ажилласан жилийг тогтоож илүү цалин олгож ирсэн байна.

Хариуцах ажилтан

ЗДТГазрын дарга Х.Тилеген, нягтлан бодогч Д.Бекболат

Эрсдэл

Цалингийн сан зориулалт бус зарцуулагдах, хэтрэх эрсдэлтэй /Тохиолдсон байх, Иж бүрэн байх, Хэмжилт, Толилуулга ба тодруулга, Үнэн зөв байдал/

Зөвлөмж

Засгийн газрын 2007 оны 354 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн албан тушаалын ангилал, зэрэглэл”, 2014 оны 332 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ”-г үндэслэн ажилтнуудын цалинг шинэчлэн тогтоох, цалингийн шатлалыг сонгохдоо төрийн алба хаасан хугацааг баримтлах,

Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтанд заасны дагуу тогтоож, аудитаар илэрсэн зөрчлүүдийг бүрэн арилгах;

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг бүрэн арилгаж ажиллахыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно

4 Аудит хийсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

4.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	58,885,960.00	40,546,252.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,080,000.00	20,090,452.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	1,080,000.00	-
31110	Төгрөг		
31140	Касс арилжааны банк	1,080,000.00	
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	20,090,452.00
3121	Төгрөг	-	20,090,452.00
31211	Төрийн сангийн харилцах		
31213	Арилжааны банк дахь харилцах		20,090,452.00
35	БАРАА МАТЕРИАЛ	57,805,960.00	20,455,800.00
351	Түүхий эд материал	-	-
35110	Тусгай зориулалттай материал		
35300	Бэлэн бүтээгдэхүүн		
354	Хангамжийн материал	57,805,960.00	20,455,800.00
35410	Бичиг хэргийн материал	16,965,300.00	3,312,200.00
35420	Аж ахуйн материал	1,491,400.00	640,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	11,321,400.00	
35440	Түлш, шатах тослох материал	741,060.00	
35450	Барилгын засварын материал	1,689,300.00	
35460	Хүнсний материал		
35470	Бусад хангамжийн материал	25,597,500.00	16,503,600.00
36	НӨӨЦИЙН БАРАА	-	-
36100	Барааны нөөц		
36600	Бусад нөөц		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,647,560,329.57	1,560,765,074.87
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,647,560,329.57	1,560,765,074.87
391	Газар		
392	Биет хөрөнгө	1,644,765,642.14	1,558,159,137.48
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,360,787,596.00	2,360,787,596.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,098,265,744.96)	(1,156,244,444.60)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	422,922,245.00	390,272,245.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(231,869,466.16)	(239,327,800.20)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	248,248,490.30	303,074,290.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	(173,406,805.30)	(196,775,478.93)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	243,410,454.00	245,030,454.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(127,776,126.60)	(149,262,723.91)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс		
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,100,000.00	1,100,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(385,000.14)	(495,000.18)
393	Биет бус хөрөнгө	2,794,687.43	2,605,937.39
39301	Програм хангамж	31,479,400.00	31,479,400.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(28,684,712.57)	(28,873,462.61)
39303	Бусад биет бус хөрөнгө		

39304	Хуримтлагдсан элэгдэл		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,706,446,289.57</u>	<u>1,601,311,326.87</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>4,706,305.00</u>	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,706,305.00	-
413	Өглөг	4,706,305.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,930,175.00	
4136	Бусад өглөг	2,776,130.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	2,776,130.00	
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,701,739,984.57</u>	<u>1,601,311,326.87</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,701,739,984.57	1,601,311,326.87
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	871,398,047.30	871,398,047.30
51101	Өмч: - төрийн	871,398,047.30	871,398,047.30
512	Хуримтлагдсан үр дүн	(11,083,435.73)	(111,512,093.43)
51210	Өмнөх үеийн үр дүн	(11,083,435.73)	(11,083,435.73)
51220	Тайлант үеийн үр дүн		(100,428,657.70)
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	841,425,373.00	841,425,373.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,706,446,289.57</u>	<u>1,601,311,326.87</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,630,457,054.00	2,242,438,919.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	369,597,457.00	629,339,312.00
120	Нийтлэг татварын бус орлого	369,597,457.00	629,339,312.00
120001	Хувьцааны ногдол ашиг		
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	369,597,457.00	629,339,312.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	52,179,135.46	21,027,960.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	681,114.54	558,052,552.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих		
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	316,737,207.00	50,258,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,260,859,597.00	1,613,099,607.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,257,488,900.00	1,609,568,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,257,488,900.00	1,609,568,100.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт		
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3,370,697.00	3,531,507.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	3,370,697.00	3,531,507.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,449,279,906.65	2,342,867,576.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,449,279,906.65	2,342,867,576.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,334,912,654.38	2,206,252,170.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	633,840,593.54	613,876,450.00
210101	Үндсэн цалин	632,540,593.54	335,270,650.00
210102	Нэмэгдэл		131,499,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,000,000.00	10,260,000.00

210104	Урамшуулал		
210105	Гэрээт ажлын хөлс	300,000.00	136,846,000.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,475,402.16	64,975,200.00
210201	Тэтгэврийн даатгал	65,475,402.16	64,975,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	174,224,100.00	163,067,093.00
210301	Гэрэл, цахилгаан	14,721,982.00	12,527,393.00
210302	Түлш, халаалт	130,089,718.00	121,125,000.00
210303	Цэвэр, бохир ус	29,412,400.00	29,414,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	112,665,110.49	91,514,535.00
210401	Бичиг хэрэг	22,063,986.00	24,280,500.00
210402	Тээвэр, шатахуун	66,770,500.00	41,968,080.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	19,565,624.49	16,860,425.00
210404	Ном, хэвлэл	4,185,000.00	7,697,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	80,000.00	708,530.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
2105	Нормативт зардал	8,085,875.00	8,849,460.00
210502	Хоол, хүнс	1,580,775.00	5,040,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,505,100.00	3,809,460.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,040,991.54	28,810,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	713,191.54	
210602	Тавилга		
210604	Урсгал засвар	27,327,800.00	28,810,400.00
2107	Томилолт, зочны зардал	55,566,795.00	41,961,500.00
210701	Гадаад албан томилолт	2,309,410.00	
210702	Дотоод албан томилолт	53,257,385.00	41,961,500.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	109,962,915.00	2,072,042.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	108,000,000.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	544,000.00	544,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	35,415.00	301,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	504,000.00	420,092.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	210,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	632,000.00	713,500.00
210807	Газрын төлбөр	37,500.00	37,500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	147,050,871.65	1,191,125,490.70
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,517,600.00	1,047,049,466.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,633,900.00	834,970.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	126,899,371.65	143,241,054.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	114,367,252.27	136,615,406.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	63,837,800.00	61,444,200.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	63,837,800.00	61,444,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,741,144.00	49,758,105.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	3,370,697.00	3,504,805.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,370,447.00	46,253,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,000,000.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,788,308.27	25,413,101.00
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,788,308.27	25,413,101.00
213304	Хөрөнгийн		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	181,177,147.35	(100,428,657.70)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз		
145003	Хөрөнгө оруулалтын олз		
145006	Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	181,177,147.35	(100,428,657.70)

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,327,152,974.00	2,192,180,119.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	52,860,250.00	579,080,512.00
120	Нийтлэг татварын бүс орлого	52,860,250.00	579,080,512.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	52,860,250.00	579,080,512.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	52,179,135.46	21,027,960.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	681,114.54	558,052,552.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,274,292,724.00	1,613,099,607.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,433,127.00	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бүс этгээдээс авсан хандив, тусламж		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,433,127.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,257,488,900.00	1,609,568,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,257,488,900.00	1,609,568,100.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт		
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3,370,697.00	3,531,507.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	3,370,697.00	3,531,507.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,310,434,074.00	2,166,012,667.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,310,434,074.00	2,166,012,667.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,196,066,821.73	2,029,397,261.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	625,888,069.92	613,369,390.00

210101	Үндсэн цалин	453,759,581.92	334,763,590.00
210102	Нэмэгдэл		131,499,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,245,488.00	10,260,000.00
210104	Урамшуулал		
210105	Гэрээт ажлын хөлс	162,883,000.00	136,846,000.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,344,625.78	64,975,200.00
210201	Тэтгэврийн даатгал	73,344,625.78	64,975,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	174,224,100.00	163,067,093.00
210301	Гэрэл, цахилгаан	14,721,982.00	12,527,393.00
210302	Түлш, халаалт	130,089,718.00	121,125,000.00
210303	Цэвэр, бохир ус	29,412,400.00	29,414,700.00
210304	Байрны түрээс		
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/		
2104	Хангамж, бараа материалын зардал	93,500,049.49	69,493,400.00
210401	Бичиг хэрэг	5,830,650.00	6,103,500.00
210402	Тээвэр, шатахуун	65,879,250.00	42,118,270.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,387,949.49	18,790,600.00
210404	Ном, хэвлэл	4,185,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	217,200.00	2,481,030.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
2105	Нормативт зардал	4,496,475.00	8,522,910.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		
210502	Хоол, хүнс	1,643,775.00	5,040,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,852,700.00	3,482,910.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,060,091.54	8,966,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,283,191.54	
210602	Тавилга		
210604	Урсгал засвар	18,776,900.00	8,966,700.00
2107	Томилолт, зочны зардал	55,566,795.00	41,961,500.00
210701	Гадаад албан томилолт	2,309,410.00	
210702	Дотоод албан томилолт	53,257,385.00	41,961,500.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	110,110,015.00	2,072,042.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	108,000,000.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	544,000.00	544,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	62,515.00	301,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	504,000.00	420,092.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	210,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	752,000.00	713,500.00
210807	Газрын төлбөр	37,500.00	37,500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,876,600.00	1,056,969,026.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,849,200.00	1,056,134,056.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	28,027,400.00	834,970.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	114,367,252.27	136,615,406.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	63,837,800.00	61,444,200.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	63,837,800.00	61,444,200.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,741,144.00	49,758,105.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	3,370,697.00	3,504,805.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,370,447.00	46,253,300.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,000,000.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,788,308.27	25,413,101.00
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,788,308.27	25,413,101.00
213304	Хөрөнгийн		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>16,718,900.00</u>	<u>26,167,452.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
140001	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	15,638,900.00	7,157,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,638,900.00	7,157,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	15,638,900.00	7,157,000.00
220001	Барилга байгууламж		
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	15,638,900.00	7,157,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(15,638,900.00)</u>	<u>(7,157,000.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1,080,000.00	19,010,452.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,080,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,080,000.00	20,090,452.00

4.4 Аудит хийсэн ЦЭВЭР ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	871,398,047.30	841,425,373.00	-11,083,435.73	1,701,739,984.57
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	871,398,047.30	841,425,373.00	-11,083,435.73	1,701,739,984.57
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			-100,428,657.70	-100,428,657.70
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	871,398,047.30	841,425,373.00	-111,512,093.43	1,601,311,326.87

4.5 Аудит хийсэн ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,257,488,900	1,309,000,777	1,609,568,100	1,584,154,999
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,257,488,900	1,309,000,777	1,609,568,100	1,584,154,999
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,174,622,600	1,211,792,530	1,501,894,100	1,475,328,799
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	614,809,000	625,888,070	590,683,200	590,589,100
210101	Үндсэн цалин	438,649,000	453,759,582	311,577,400	311,983,300
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,260,000	9,245,488	10,260,000	10,260,000
210104	Урамшуулал				
210105	Гэрээт ажлын хөлс	165,900,000	162,883,000	136,846,000	136,846,000
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,629,200	73,344,626	64,975,200	64,975,200
210201	Тэтгэврийн даатгал	67,629,200	73,344,626	64,975,200	64,975,200
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	174,224,100	174,224,100	164,820,200	163,067,093
210301	Гэрэл, цахилгаан	13,000,000	14,721,982	14,280,500	12,527,393
210302	Түлш, халаалт	131,809,400	130,089,718	121,125,000	121,125,000
210303	Цэвэр, бохир ус	29,414,700	29,412,400	29,414,700	29,414,700
2104	Хангамж, бараа материалын зардал	87,709,200	94,419,949	67,891,400	70,268,030

210401	Бичиг хэрэг	6,385,600	5,830,650	6,467,500	6,103,500
210402	Тээвэр, шатахуун	54,907,500	65,879,250	40,636,700	41,633,800
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16,816,300	17,387,949	17,813,200	18,790,600
210404	Ном, хэвлэл	8,319,800	4,185,000		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,280,000	1,137,100	2,974,000	3,740,130
2105	Нормативт зардал	2,490,000	4,496,475	3,320,000	3,482,910
210502	Хоол, хүнс		1,643,775		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,490,000	2,852,700	3,320,000	3,482,910
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,189,600	31,886,900	8,074,400	8,566,700
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000,000	13,110,000		
210604	Урсгал засвар	9,189,600	18,776,900	8,074,400	8,566,700
2107	Томилолт, зочны зардал	53,626,200	55,566,795	31,089,600	33,440,400
210701	Гадаад албан томилолт	5,600,000	2,309,410		
210702	Дотоод албан томилолт	48,026,200	53,257,385	31,089,600	33,440,400
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах				
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	113,445,300	110,110,015	4,260,000	2,072,042
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	109,145,300	108,000,000		
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	544,000	544,000	544,000	544,000
210803	Даатгалын үйлчилгээ	1,158,600	62,515	1,158,600	301,950
210804	Тээврийн хэрэгслийн татвар	504,000	504,000	504,000	420,092
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	210,000	210,000	210,000	55,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500,000	752,000	1,500,000	713,500
210807	Газрын төлбөр	113,400	37,500	113,400	37,500
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	270,000		230,000	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,500,000	41,855,600	566,780,100	538,867,324
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000	11,194,200	565,655,100	538,092,354
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	31,500,000	30,661,400	1,125,000	774,970
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	82,866,300	97,208,247	107,674,000	108,826,200
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	63,837,800	63,837,800	61,420,700	61,444,200
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	63,837,800	63,837,800	61,420,700	61,444,200
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,028,500	33,370,447	46,253,300	47,382,000

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,528,500	16,370,447	46,253,300	47,382,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,500,000	17,000,000		
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,257,488,900	1,269,082,892	1,609,568,100	1,584,154,999
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,257,488,900	1,269,082,892	1,609,568,100	1,584,154,999
132001	Орон нутгийн төсвөөс	1,257,488,900	1,269,082,892	1,609,568,100	1,584,154,999
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	65	65	65	66
620001	Удирдах ажилтан	10	10	10	11
620002	Гүйцэтгэх ажилтан	22	22	22	22
620003	Үйлчлэх ажилтан	33	33	33	33
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	65	65	65	65
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	32	32	32	32
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	3	3	3	3
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	3	3	3	3
650010	Гэрээт ажилтан	25	25	25	25
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	2	2	2	2

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Огноо: 2017.02.24

М.ХУАНГАН

АУДИТЫН МЕНЕЖЕР
Огноо: 2017.02.24

Х.ЖЕНИСБЕК

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Б.ҮҮРИЙНТУЯА

Огноо: 2017.02.24